



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 09 сарын 25 өдөр

Дугаар 4/89

Модот

**Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх
дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8 дахь заалт, Хэнтий аймгийн мал эмнэлгийн газрын даргын 2024 оны А/51 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1.Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын арга хэмжээг төлөвлөгөөт хугацаанд зохион байгуулах, Урьдчилан сэргийлэх дархлаажуулалтанд ажиллах хүн хүч машин техник шатах тослох материаллын бэлэн байдлыг хангаж ажиллахыг мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд даалгасугай.

2.Урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын хуваарийг хавсралтаар баталсугай.

3.Дархлаажуулалт хийх ажлыг малчидад урьдчилан мэдэгдэж тарилгын хашаа, хоолойг бэлтгүүлэн мал сүргээ бэлэн байлгаж, бэлтгэл хангуулахыг Багийн Засаг дарга нарт даалгасугай.

4.Урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад мал сүргээ бүрэн хамруулаагүй, хамруулахаас зайлс хийсэн малчид мал бүхий иргэд, заавар журмыг баримтлаагүйн улмаас малын өвчин гарах нөхцөлийг бүрдүүлсэн этгээдэд хуулийн дагуу арга хэмжээ тооцож ажиллах, дархлаажуулалтанд шаардлагатай вакцин татан авах, мэргэжил арга зүйн заавар зөвлөмжөөр хангах, гүйцэтгэлд хяналт хийн ажиллахыг мал эмнэлгийн улсын байцаагч (П.Ганчимэг) - т үүрэг болгосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ү.Ичинхорлоо)-д даалгасугай

ЗАСАГ ДАРГА

С.ЗОЛЖАРГАЛ



Сумын Засаг даргын 2024 оны
09 дүгээр сарын 25-ны өдрийн
А/89 дүгээр захирамжийн хавсралт

**Бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтанд хамрагдах мал,
тарилгын хуваарь**

№	Аж ахуйн нэр	Хамрагдвал зохих малын тоо			Бүгд	Шаардагдах вакцин\тун\	Шингэлэгч
		Тугал	Хурга	Ишиг		тун	л
1	Дэрст хайрхан МЭҮН	2480	15163	10437	28080	30560	30560
2	Үржих баян мандал МЭҮН	720	6031	3569	10320	11040	11040
3	Цэнхэр бэлчир МЭҮН	640	2537	1863	5040	5680	5680
	Бүгд	3840	23731	15869	43440	47280	47280

0000